

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2025/157/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2025 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: У.Ербол Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
Аймгийн ИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Төсвийн захирагч



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ж.БЕКАРЫС ТАНАА

2025.02.25 № 233
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Булган сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд 3,873.0 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 3,873.0 сая төгрөг зарцуулж, 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>285,977,546.18</u>	<u>369,951,215.04</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	136,515,943.00	179,954,206.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	136,515,943.00	179,954,206.00
3121	Төгрөг	136,515,943.00	179,954,206.00
31211	Төрийн сангийн харилцах	136,515,943.00	179,954,206.00
33	АВЛАГА	33,029,203.18	3,256,811.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	29,179,303.18	559,811.00
335	Бусад авлага	3,849,900.00	2,697,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,849,900.00	2,697,000.00
34	УРЬДЧИЛГАА	4,045,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	4,045,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	112,387,400.00	186,740,198.04
354	Хангамжийн материал	112,387,400.00	186,740,198.04
35420	Аж ахуйн материал	64,307,300.00	102,952,278.04
35440	Түлш, шатах тослох материал	20,800.00	9,438,800.00
35460	Хүнсний материал	48,059,300.00	74,349,120.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,247,130,287.20</u>	<u>5,294,879,397.03</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,247,130,287.20	5,294,879,397.03
392	Биет хөрөнгө	4,190,065,048.20	5,238,525,777.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,895,338,088.04	5,248,928,051.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	(358,326,537.38)	(442,959,436.22)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	311,637,015.00	507,539,655.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(164,329,129.52)	(212,718,792.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	105,427,933.00	141,103,133.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(69,127,193.72)	(75,800,860.98)
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,635,848.95	26,635,848.95
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,824,554.15)	(4,393,659.05)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	1,412,036,447.00	-
39217	Ном	33,597,130.98	50,191,838.12
393	Биет бус хөрөнгө	57,065,239.00	56,353,619.44
39301	Програм хангамж	1,973,239.00	1,973,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(1,261,619.56)
39303	Бусад биет бус хөрөнгө	55,642,000.00	55,642,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	<u>4,533,107,833.38</u>	<u>5,664,830,612.07</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>19,852,000.00</u>	<u>23,111,840.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,852,000.00	23,111,840.00
413	Өглөг	19,852,000.00	23,111,840.00
4136	Бусад өглөг	19,852,000.00	23,111,840.00

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41361	Байгууллагад төлөх өглөг	19,812,000.00	23,111,840.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	40,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,513,255,833.38</u>	<u>5,641,718,772.07</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,513,255,833.38	5,641,718,772.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	599,304,069.00	599,304,069.00
51101	Өмч: - төрийн	599,304,069.00	599,304,069.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,617,621,986.27	2,746,084,924.96
51210	Өмнөх үеийн үр дүн	110,797,303.99	1,617,621,986.27
51220	Тайлант үеийн үр дүн	1,506,824,682.28	1,128,462,938.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,296,329,778.11	2,296,329,778.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,533,107,833.38</u>	<u>5,664,830,612.07</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,295,342,252.98	5,023,687,441.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,321,000.00	1,155,195,341.18
120	Нийтлэг татварын бус орлого	29,321,000.00	1,155,195,341.18
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,800,000.00	1,155,195,341.18
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,800,000.00	4,510,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	1,111,019,463.14
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	26,521,000.00	39,665,878.04
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,266,021,252.98	3,868,492,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,145,750,252.98	3,693,966,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,694,888,200.00	3,693,966,900.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	1,450,862,052.98	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	120,271,000.00	174,525,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	120,271,000.00	174,525,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,788,517,570.70	3,895,224,502.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,788,517,570.70	3,895,224,502.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,738,548,196.70	3,832,624,701.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,975,530,649.00	2,923,668,151.58
210101	Үндсэн цалин	1,353,058,617.00	2,006,643,721.58
210102	Нэмэгдэл	545,548,632.00	854,679,000.00
210104	Урамшуулал	76,923,400.00	62,345,430.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	247,175,345.82	370,420,547.70

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210201	Тэтгэврийн даатгал	167,211,872.82	253,159,751.00
210202	Тэтгэмжийн даатгал	20,544,593.00	29,185,750.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,845,035.00	23,348,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,961,259.00	5,837,650.00
210205	Эрүүл мэндийн даатгал	39,612,586.00	58,888,796.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,944,439.00	145,758,639.10
210301	Гэрэл, цахилгаан	12,200,903.00	14,381,339.10
210302	Түлш, халаалт	126,743,536.00	131,377,300.00
2105	Нормативт зардал	171,844,530.00	145,190,170.00
210502	Хоол, хүнс	171,844,530.00	145,190,170.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,395,000.00	7,792,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,395,000.00	7,792,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	194,658,232.88	239,795,193.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,207,570.00	80,818,239.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,521,600.00	17,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	116,929,062.88	141,976,953.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,969,374.00	62,599,800.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,966,550.00	62,599,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	49,966,550.00	62,599,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,824.00	0.90
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,824.00	0.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,506,824,682.28	1,128,462,938.69
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,506,824,682.28	1,128,462,938.69

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,817,959,200.00	3,873,002,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,800,000.00	4,510,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,800,000.00	4,510,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,800,000.00	4,510,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,800,000.00	4,510,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,815,159,200.00	3,868,492,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,694,888,200.00	3,693,966,900.00

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,694,888,200.00	3,693,966,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	120,271,000.00	174,525,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	120,271,000.00	174,525,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,667,352,926.00	3,776,330,637.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,667,352,926.00	3,776,330,637.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,592,271,302.00	3,714,692,766.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,994,989,733.00	2,924,266,487.00
210101	Үндсэн цалин	1,372,517,701.00	1,976,026,270.00
210102	Нэмэгдэл	545,548,632.00	863,309,417.00
210104	Урамшуулал	76,923,400.00	84,930,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	258,585,300.00	341,066,720.00
210201	Тэтгэврийн даатгал	175,838,200.00	231,048,020.00
210202	Тэтгэмжийн даатгал	20,686,600.00	27,504,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,549,400.00	13,752,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,137,600.00	13,752,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	41,373,500.00	55,009,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,168,239.00	173,305,199.10
210301	Гэрэл, цахилгаан	6,851,000.00	6,851,000.00
210302	Түлш, халаалт	112,317,239.00	166,454,199.10
2105	Нормативт зардал	140,671,180.00	172,481,920.00
210502	Хоол, хүнс	140,671,180.00	172,481,920.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,220,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,220,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,652,841.00	26,382,510.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,800,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,852,841.00	26,382,510.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,104,009.00	75,969,930.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,134,909.00	56,079,730.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,969,100.00	19,890,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,081,624.00	61,637,870.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,078,800.00	61,637,870.00

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	75,078,800.00	61,637,870.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,824.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,824.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	0.90
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		0.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>150,606,274.00</u>	<u>96,671,463.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	49,655,000.00	53,233,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	49,655,000.00	53,233,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	49,655,000.00	53,233,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	49,655,000.00	53,233,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(49,655,000.00)</u>	<u>(53,233,200.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	100,951,274.00	43,438,263.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		136,515,943.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		179,954,206.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	599,304,069.00	2,296,329,778.11	110,797,303.99		3,006,431,151.10
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00		0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	599,304,069.00	2,296,329,778.11	110,797,303.99	0.00	3,006,431,151.10
C07	Тайлант үеийн үр дүн			1,506,824,682.28		1,506,824,682.28
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	599,304,069.00	2,296,329,778.11	1,617,621,986.27	0.00	4,513,255,833.38
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	599,304,069.00	2,296,329,778.11	1,617,621,986.27	0.00	4,513,255,833.38
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	599,304,069.00	2,296,329,778.11	1,617,621,986.27	0.00	4,513,255,833.38
D08	Тайлант үеийн үр дүн			1,128,462,938.69		1,128,462,938.69
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	599,304,069.00	2,296,329,778.11	2,746,084,924.96	0.00	5,641,718,772.07

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

БӨА-2025/157/НА-СТА-ТШЗ

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		136,515,943.00		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,011,573,600.00	3,829,563,836.10	(182,009,763.90)	95.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,011,573,600.00	3,829,563,836.10	(182,009,763.90)	95.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,933,793,600.00	3,767,925,966.10	(165,867,633.90)	95.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,993,234,400.00	2,924,266,487.00	(68,967,913.00)	97.7
210101	Үндсэн цалин	2,058,037,600.00	1,976,026,270.00	(82,011,330.00)	96.0
210102	Нэмэгдэл	864,713,300.00	863,309,417.00	(1,403,883.00)	99.8
210104	Урамшуулал	70,483,500.00	84,930,800.00	14,447,300.00	120.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шим	374,154,300.00	341,066,720.00	(33,087,580.00)	91.2
210201	Тэтгэврийн даатгал	254,424,900.00	231,048,020.00	(23,376,880.00)	90.8
210202	Тэтгэмжийн даатгал	29,932,300.00	27,504,600.00	(2,427,700.00)	91.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,966,200.00	13,752,400.00	(1,213,800.00)	91.9
210204	Ажилгүйдлийн даатгал	14,966,200.00	13,752,400.00	(1,213,800.00)	91.9
210205	Эрүүл мэндийн даатгал	59,864,700.00	55,009,300.00	(4,855,400.00)	91.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	175,331,000.00	173,305,199.10	(2,025,800.90)	98.8
210301	Гэрэл, цахилгаан	6,851,000.00	6,851,000.00	-	100.0
210302	Тулш, халаалт	168,480,000.00	166,454,199.10	(2,025,800.90)	98.8
2105	Нормативт зардал	214,390,000.00	172,481,920.00	(41,908,080.00)	80.5
210502	Хоол, хүнс	214,390,000.00	172,481,920.00	(41,908,080.00)	80.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,220,000.00	(280,000.00)	81.3
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,220,000.00	(280,000.00)	81.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төл	48,134,000.00	45,419,710.00	(2,714,290.00)	94.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйл	4,510,000.00	4,510,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	43,624,000.00	40,909,710.00	(2,714,290.00)	93.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	127,049,900.00	110,165,930.00	(16,883,970.00)	86.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	107,159,700.00	90,275,730.00	(16,883,970.00)	84.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,890,200.00	19,890,200.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,780,000.00	61,637,870.00	(16,142,130.00)	79.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	77,780,000.00	61,637,870.00	(16,142,130.00)	79.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	77,780,000.00	61,637,870.00	(16,142,130.00)	79.2
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,011,573,600.00	3,873,002,099.10	(138,571,500.90)	96.55
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,693,966,900.00	3,693,966,900.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,693,966,900.00	3,693,966,900.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	176,831,000.00	174,525,199.10	(2,305,800.90)	98.70
132001	Орон нутгийн төсвөөс	176,831,000.00	174,525,199.10	(2,305,800.90)	98.70
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	140,775,700.00	4,510,000.00	(136,265,700.00)	3.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,510,000.00	4,510,000.00	-	100.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	136,265,700.00		(136,265,700.00)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		136,515,943.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		179,954,206.00		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО		1	-	
610001	Төсвийн байгууллага		1	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	128	127	1	
620001	Удирдах ажилтан	1	1	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	78	77	1	
620003	Үйлчлэх ажилтан	38	38	-	
620004	Гэрээт ажилтан	11	11	-	
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	760	740	20	
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУР	760	740	20	
630001	Төрийн өмчит ЕБС	760	740	20	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	128	127		
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	79	79		
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч	1	1		
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч	2	2		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч	1	1		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	34	34		
650010	Гэрээт ажилтан	11	11		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Булган сумын Ерөнхий боловсролын сургууль нь иргэн бүрийн насан туршийн амьдралын чанарыг дэмжин баталгаажуулах, улс орны нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түлхүүр хүчин зүйлсийг дэмжих нь байгууллагын зорилго оршино.

Багш мэргэжилтэний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, бага боловсрол эзэмшүүлэх, чанартай сургалт явуулах, хууль шинжлэх ухааны үндэслэлийг ахиулахад анхаарах, эрдэм мэдлэгээрээ гэрэлт ирээдүйгээ цогцлоон бүтээх шинэ үеийн шилдэг сурагчдыг бэлгэх гэсэн зорилтууд дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Булган сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Булган сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны А/09 тоот тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,128.4 сая төгрөгөөр буюу 25.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	136,515.9	179,954.2	43,438.3
Авлага	33,029.2	3,256.8	(29,772.4)
Урьдчилгаа	4,045.0	0	(4,045.0)
Бараа материал	112,387.4	186,740.2	74,352.8
Үндсэн хөрөнгө	4,247,130.3	5,294,879.1	1,047,749.1
Нийт хөрөнгө	4,533,107.8	5,664,830.6	1,131,722.8
Өр төлбөр	19,852.0	23,111.8	3,259.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,513,255.8	5,641,718.7	1,128,462.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,533,107.8	5,664,830.6	1,131,722.8

Мөнгөн хөрөнгө нь өмнөх оноос 43.4 сая төгрөгөөр нэмэгдэж, дансны авлага 29.7 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын данс 74.4 сая төгрөгөөр өссөн нь хүнс, аж ахуйн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 1,047.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь шинээр спорт заал, сургуулийн дээвэр, гал тогооны дээврийн засварыг орлого авсантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант оны үр дүнгээр 1,128.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,781.6 сая, орон нутгийн төсвөөс 35.0 сая төгрөг, нийт зарлагыг 3,016.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн төслийн саналаас 499.8 сая төгрөгөөр бууруулж 2,516.9 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 3,834.7 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 176.8 сая төгрөг, нийт 4.011.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,693.6 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 174.5 сая төгрөгийн санхүүжилтийг авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 4.5 сая төгрөгийн орлогыг оруулж, оны эхний үлдэгдлээс 136.2 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,829.5 сая төгрөг буюу 95.4 хувьтай, дансанд 179.9 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
80217	Мэдээлэл технологийн үйлчилгээ	3,580.8	0	3,580.8	
80826	Байр ашиглалтын үйлчилгээ	4,882.9	4,882.9	0	100
80223	Хүүхэд хамгаалал	4,957.8	4,957.8	0	100
80312	Сургалт семинар	3,360.2	3,360.2		100
81605	Эрүүл мэндийг дэмжих	6,282.9	3,540.0	2,742.9	56.3
81801	Үдийн цай хөтөлбөр	77,780.0	61,637.8	16,142.1	79.2
81806	Дотуур байрны үйлчилгээ	782,731.4	736,484.4	46,246.9	94.1
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	35,573.5	35,573.5	0	100
81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	15,233.7	2,700.0	12,533.7	17.7
81827	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	22,368.6	20,265.7	2,102.9	90.6
81834	Боловсролын стандарт, сургалтын	2,793,670.2	2,702,565.4	91,104.8	96.6
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	72,991.0	70,455.5	2,535.5	96.5
81848	Сурах бичгийн түрээс	4,510.0	4,510.0	0	100
81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	6,819.6	4,105.3	2,714.3	60.2
88011	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	176,831.0	174,525.1	2,305.9	98.7
	Дүн	4,011,573.6	3,829,563.8	185,590.6	95.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

- Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу сан байгуулаагүй, ахмадын сангийн харилцах данс нээлгээгүй байна.
- БНАҮТХураамжийн данснаас номын түрээсээс орж ирсэн орлогоос 4.4 сая төгрөгний зардал гарсан байна. Бусад бараа үйлчилгээний бусад данснаас 81.9 сая төгрөгний зардал гарсан үүнээс 36.9 сая төгрөг нь Монголын цахилгааны холбоо компаниас Ерөнхий гэрээгээр худалдан авсан интернет төхөөрөмжийн үнэ байна.
- Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулж авч, хянаж үзэхэд батлагдсан орон тооны хязгаарыг баримталж ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Байхгүй

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Булган сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Булган сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж ажиллаагүй байна.

Батлагдсан төсвийн хүрээнд 398.5 сая төгрөгийн бараа материал, 78.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.5 хувиар тогтоосон суурь үзүүлэлтээр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 31,370.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж тайлант оны нийт зардлын дүн их хэмжээгээр өөрчлөгдсөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 75 хувиар буюу 59,706.7 мянган төгрөгөөр тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 3,838.3 сая төгрөгийн 51 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 140.6 сая төгрөгийн 20 мэдээллийг оруулахаас, мэдээлбэл зохих бүх мэдээллийг цаг тухайд нь бүрэн мэдээлж ажилласан байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 97.1 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 43.2 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөгдсөн ба бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	43,187.6	2	43,187.6	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан цалингийн зардал, хөрөнгийн тооллогыг түүвэрлэн шалгасан тул гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **3,580.6** мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад **3,580.6** мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайланд бараа үйлчилгээний бусад зардлын төлөвлөгөөг 3,580.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулав.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-ийн 4.1.3, 5 дугаар зүйл 5.1-ийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Сангийн сайдын 2023 оны А/229 тоот тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" болон УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 12,049.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 2,513.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 5,026.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 4,510.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

Байхгүй.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.
БӨА-2025/157/НА-СТА-ТШЗ

5.1 Төлбөрийн акт

1. Сургуулийн захирлын 2024 оны А/12 дугаар тушаалаар “Балансын урамшуулал олгох тухай” нягтлан бодогч, нярав нарт 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан гэж 5,026.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон боловч 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн Б/45 дугаар тушаалаар нягтлан бодогч, нярав нарт дахин нэг сарын цалингаар 2,513.0 мянган төгрөгийн урамшуулал олгож төсвийг зүй бус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3-т “*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*”, Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д “*Үнэн зөв байх*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар 5,026.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

3. Сургуулийн захирлын 2024 оны “Балансын урамшуулал олгох тухай” А/12 дугаар тушаалаар үндэслэн нягтлан бодогч, нярав нарт 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан гэж 5,026.0 мянган төгрөгийн урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5-ийн 16.5.5, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сургууль нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй /дотуур байрны хоол хүнс 172.5 сая төгрөг, үдийн хоол 61.6 сая төгрөг г.м/ байна.

Эн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.”, 46.1-т “Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана.” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.2 Илрүүлэлт:

Тайлант онд 4,510.0 мянган төгрөгийн түрээсийн сурах бичгийг сурагчдад тараасан боловч авлагаар бүртгээгүй, тооцооны данс дамжуулахгүйгээр шилжүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтууд, иж бүрэн байх, ангилал, оршин байх гэсэн батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Түрээсийн сурах бичгийг авлагаар бүртгэж тайлагнаж байх.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТГТ-д бараа үйлчилгээний бусад зардлын төлөвлөгөөг 3,580.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	3,580.6			1	3,580.6	1	3,580.6				
Дүн	1	3,580.6			1	3,580.6	1	3,580.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Балансын шагнал давхар олгосон	1	2,513.0	1	2,513.0								
Хууль тогтоомж зөрчин балансын шагнал олгосон	1	5,026.0			1	5,026.0						
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй	1	0					1	0				
Түрээсийн сурах бичгийг сурагчдад тараасан боловч авлагаар бүртгээгүй, тооцооны данс дамжуулахгүйг ээр шилжүүлсэн	1	4,510.0					1	4,510.0				
Дүн	4	12,049.0	1	2,513.0	1	5,026.0	2	4,510.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт дүн								